

Шувууны томуугийн вирус * хүнд

Ахуй хавьтлын зам: Өвчтэй буюу үхсэн шувуудтай хүрэлцсэн (нядлах, арчлах, тордох үед) юм уу, шувууны сангасаар бохирдсон ус, хөрс, эд зүйлстэй харьцсан үед

Хоол хүнсний зам: Шувууны томуугийн халдвартай хүнсний зүйл, шувууны гаралтай мах, өндөг хэрэглэх үед

Агаар, дуслын зам: Өвчилсөн хүний ярих, найтаах болон өвчтөний гуурсан хойлоог дуранах явцад нүдэнд үл үзэгдэх дуслуудаас халдвар авна. Мөн шувууны томуугаар өвчилсөн шувуудын байрны агаар бохирдож тоосонцор үүсч тэр нь ажиллагсадын нүдний салст, амьсгалын дээд замаар халдвар авах үүд хаалга болдог байна.

Шувууны томуугийн вирус

Байгаль дээр халдвар дамжих зам: Сул хоруу вирус нь шувуун сүрэгт хоол боловсруулах болон амьсгалын замаар дамжин усны зэрлэг шувуун сүргийн дунд эргэлдэж байдаг байна. Мөн шувууны сангасаар бохирдсон ус, тэжээлийн тэвш зэргээр дамжиж болдог байна.


Шувууны томуугийн вирус нь гадаад орчинд ялангуяа ил задгай усанд халдварлуулах чадвараа удаан хугацаагаар хадгалж чаддаг онцлогтой байна.

Үүнд 17 хэмтэй ил усанд шувууны томуугийн вирус халдварлуулах чадвараа 100 гаруй хоног хадгалах чадвартай бөгөөд -50 хэмд удаан хугацаагаар халдварлуулах чадвараа хадгалдаг. Энэ нь сэрүүн бүсийн тогтмол нуурууд хөлдөхөд вирус халдварлуулах чадвараа хавар мөс хайлтал хадгалагдсанаар дараа жилийн шинэ үр төл халдвар авах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Усны зэрлэг шувуудаас шувууны томуугийн вирус гэрийн тэжээвэр шувуудад халдварлан дамжихад дөхөм үзүүлдэг нөхцөл нь гэрийн тэжээвэр шувууд задгай бэлчээрлэдэг байх, гэрийн тэжээвэр шувуудын ус, хүнс нь зэрлэг шувуудын сангасаар бохирдох явдал юм.

ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТАНДАЛТ СУДЛАГАА, ОНОШЛОГОО, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

| Огноо | Конвенцийн нэр |
|--|--|
|  Бонн хотноо 1979 онд батлагдсан | “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц” |
|  Монол 1971 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Рамсар хотноо гарын үсэг зурсан | “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Конвенц” |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ



АМЬТНЫ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/



ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ



МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ



“АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛГЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА АГЕНТЛАГИЙН ДАРГЫН ТУШААЛ тандалт болон хариу арга хэмжээ авах заавар





| Батлуулсан газар | Нэр | Батлагдсан огноо | Зохицуулалт |
|--|--|------------------|---|
| Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/65 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт | Шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар avian influenza, птичий грипп | 2018 он | Ерөнхий мэдээлэл, оношлогоо, урьдчилан арга хэмжээ зэргийг төлөвлөсөн |
| Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/187 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт | Өндөр хоруу чанартай вирусээр үүсгэгдсэн шувууны томуу өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээний заавар. (a-06, hpai- highly pathogenic avian influenza) | 2019 он | Хариу арга хэмжээг зохион байгуулах талаар оруулсан. |
| Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/187 дугаар тушаалын 5 хавсралт | Шувууны томуу өвчнийг тандах, мөрдөн шалгах хуудас. | 2019 он | Загвар хуудас |
| Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/187 дугаар тушаалын 6 хавсралт | Шувууны томуу өвчний тандалт хийх заавар | 2019 он | Тандалтын цэгүүдийг тодорхойлж, төлөвлөсөн. |
| Зоонозын Өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын А/32 тушаал | Шувууны тандалт судалгааны заавар | 2021 он | Зэрлэг болон тэжээвэр шувуудыг тандан судлах |

Олон улсын өвчний төлөв байдал

2023 оны 1 сараас хойш 67 улсын газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувууд, хөхтөн амьтдын дунд нийт 2100 тохиолдол бүртгэгдээд байна. Сүүлийн 5 жилд өндөр хоруу H5N1 томуугийн вирусээр 8 хүн өвдөж 2 нь нас барсан байна.

Нүүдлийн шувуудын 9 гол зам байдаг. Монгол орныг 3 зам дайран өнгөрдөг



ШУВУУНЫ ТОМУУГИЙН ХАЛДВАРЫН МЭДЭЭ (2023.10.16)

Монгол улсад нүүдлийн шувуудын тархалт

- 19 баг
- 60 овог
- 202 төрөл
- 520 гаруй зүйлийн шувууд бүртгэгдсэн

Эдгээрээс амьдрах хэлбэрийн хувьд

- 81 зүйл нь суурин,
- 387 зүйл нүүдлийн шувуудаас
- 247 зүйл нь өндөглөн зусдаг,
- 52 зүйл нь дайрч өнгөрдөг,
- 10 зүйл шувуу Сибирээс ирж өвөлждөг,
- 9 зүйл шувуу зөвхөн зусдаг, 67 зүйл шувуу нь тохиолдлын байдлаар тааралддаг



Идэвхитэй болон идэвхигүй тандалт



Монгол оронд 2005-2012 оны хооронд H5N1 өндөр хоруу чанар хэв шинжийн вирус нүүдлийн шувуудын дунд Хөвсгөл аймгийн Эрхэл, Дөрөө цагаан, Булган аймгийн Хунт нуур, Архангай аймгийн Өгий, Дойтын цагаан, Сүхбаатар аймгийн Ганга нууранд шувуудын дунд бүртгэгдсэн байна.



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ
ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ
ТУТМЫН МЭДЭЭ №12

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2023 оны 09-р сарын 29 нээс 10-р сарын 16-ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.
2023 оны 10 сарын 13 нд Сүхбаатар дүүргийн салбийн зусланд гэрийн цооног шувуу мөргөсөн гэж иргэн мэдэгдсэн. Шувууд шилэн барилга болон айлын цонхон дээр буусан модны тусгалыг андуурж мөргөж, үхэх тохиолдол бүртгэгдэх нь элбэг байдаг. Иймд цонхны гадна талыг савангаар зурах эсвэл цооног дотор талаас зураг, дүрс наах зэргээр шувуудыг хамгаалах шаардлагатай.



Зураг 1. Шивэр хөтүү

Зураг 2. Хаварсан цонх

Идлэг шонхор шувууны шинжилгээ

Шувуу хамгаалах төвтэй хамтран Идлэг шонхор махчин 5000 үүрний идлэг шонхор шувуунаас томуу иорүүлэх шинжилгээ хийсэн.

2023 онд Дундговь аймгийн Гурвансайхан, Адаацаг, Төв аймгийн Бүрэн, Баян, Баянжаргалан, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Уулбаян, Халзан, Хэнтий аймгийн Дархан, Баянмөнх сумдаас шувуунаас залгиур, хойд сүвний арчдас 200, 100 шувууны өдөнд шувууны томуугийн А хүрээний вирусн өвөрмөц РНХ тодорхойлох молекул биологийн шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Шинжилгээгээр бодит цагийн УТ-ПГУ-аар шувууны томуугийн А хүрээний М уураг тодорхойлогч генийн өвөрмөц хэсэг тодорхойлогдоогүй.



ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДАД “НЭГ ЭРҮҮЛ МЭНД – ЗООНОЗ” ДАДЛАГА, СУРГУУЛИЛАЛТ

Тус сургалтад МЭЕГ, ОБЕГ, ЗӨСҮТ, ХӨСҮТ, УМЭАЦТЛ, Мал эмнэлгийн хүрээлэн, НМЭГ,НЗӨСТ, Төвийн бүсийн 8 аймгийн ЭМГ, ЗӨСТ, МЭГ, БОГ нийт 60 гаруй мэргэжилтэн оролцож байна. Нэг эрүүл мэнд, зоонозын халдварт өвчний чиглэлээр салбар хоорондын хамтарсан багууд дадлага, сургуулилалтыг шувууны томуугийн өвчлөл бүртгэгдсэн үед авах арга хэмжээний талаар хийв.



Шувууны өвчлөл бүртгэгдсэн үед

1. Монгол улсын шадар сайдын 2023 оны тушаалын 28 тоот [“Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын салбар хоорондын мэдээлэл солилцох, үеийн хариу арга хэмжээг шүүрхай зохион байгуулах журам”](#) дагуу ажиллана.
2. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/187 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт “Өндөр хоруу чанартай вирусээр үүсгэгдсэн шувууны томуу өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээний заавар” дагуу халдваргүйжүүлэх, устгах ажлыг зохион байгуулна.
3. Зоонозын Өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын А/32 тушаалын “Шувууны томуугийн тандалт судалгаа”

Цаашид шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлж, хийж гүйцэтгэх зарим ажил:

Шувууны амьдрах орчин устгах, бохирдох, хуурайшилт зэрэг шалтгаанаар шувууны гаралтай өвчин шинээр дэгдэх, дахин сэргэх эрсдэлтэй тул дараах чиглэлээр бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай. үүнд:





ШУВУУНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИД:

ШУВУУГААР ДАМЖИХ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Тэжээвэр шувууг худалдан авах, зарахдаа анхааралтай болгоомжтой хандах

Шувууны гаралтай түүхий эдийг хагас боловсруулсан байдлаар хэрэглэхгүй байх

Гараа тогтмол угааж хэвших


Шувууны байранд орох болон гарахдаа гутлаа тогтмол цэвэрлэх

Нүүдлийн шувууд болон төв суурин газрын бусад шувуудаас тусгаарлах



+976 70282853 Nczd@nczd.gov.mn

www.nczd.gov.mn Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18151



ШУВУУНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИД

Шувууны томуу овчноос урьдчилан сэргийлье!!!

АНХААР!!!

Тэжээвэр шувууд зэрлэг шувуудаас халдвар авсан тохиолдлууд олон улсад бүртгэгдсээр байна.

Хэрэв ондор хатуурах, толгой өндлөх, ядрах зэрэг ханнадны шинж тэмдэг илэрвэл маск зүүж, эрүүд мэндийн байгууллагад (Түргэн тусламжийн төв-103, ХОСУТ-11458699, ЗОСУТ-7028 2853) хандах шаардлагатай.

Алхам 1. Цэвэрлэгээ

Гараа тогтмол савандаж угаах, шувууны байрт орох болон гарахдаа гутлаа цэвэрлэх, цэвэрлэгээг тогтмол хийх, лэрэгч амьтад орж гарах нүүхийг битүүрэх

Алхам 2. Хооллох хэсэг

Асгасан хоол тэжээл, усыг тогтмол цэвэрлэн авах, хашааг зэрлэг шувууд бууж ирэхээс хамгаалж тороор бүтээх

Алхам 3. Хашаа

Галаад орчинд сул чөлөөтэй явж зэрлэг шувуудын амьдрах орчинтой давхцахаас сэргийлж, торон хашаа барих

Шувууны томуугийн халдвар тархах зам

Шувууд

- Нүүдлийн шувууд халдварыг удаан хугацаанд, хол зайд тараадаг.
- Тэжээвэр шувуудын худалдаа
- Бохирдсон шувууны үүр
- Халдвартай өндөгний гадаргуу болон ховрол

Техник хэрэгсэл

- Халдвартай шувууны сангас бүхий нуурын эргээр техник хэрэгсэлээр явах, явган явах тохиолдолуудад
- Шувууны түүхий эд зарах зах худалдааны төв

Бусад

- Сэг зэм болон богино зайд агаар дуслын замаар тархаж болно
- Мэргэнд болон шавьжаар
- Бохирдсон нуурын ус

+976 70282853 www.nczd.gov.mn

nczd@nczd.gov.mn Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18151

АНХААРАЛ ШАГНАСАНД БАЯРЛАЛАА

